



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/226

Мөрөн сум

Бүх нийтийн их цэвэрлэгээ  
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5, 9.4.6, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02 албан даалгавар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 05 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 07 албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалын улирал эхэлсэнтэй холбогдуулан нутаг дэвсгэрийн хэмжээнд гэр хорооллын бүсийн гудамж талбай, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд болон автозамын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, малын сэг зэмийг халдваргүйжүүлэн устгах, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хашаа, хайсны өнгө үзэмжийг сэргээх ажлыг 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.


2. Хог хаягдлыг цэвэрлэх ажлын ерөнхий удирдамжийг нэгдүгээр, тайлан ирүүлэх хүснэгтийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аймгийн хэмжээнд нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлын хүрээнд сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж, холбогдох тайлан мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

4. Хог хаягдлыг цэвэрлэх ажлыг сум бүр үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671 010003



Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 10-ны өдрийн  
А/ 226 дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт

## УДИРДАМЖ

Бүх нийтийн цэвэрлэгээ хийх ажлын тухай

**Зорилго.** Хог хаягдлын тухай хуулийн 9.4.3, 9.4.5, 9.4.6, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны 02 албан даалгавар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 05 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 07 албан даалгавруудын хэрэгжилтийг хангах, байгалиа дээдэлсэн, дарж булах хогны хэмжээг тогтмол бууруулсан, тогтвортой хөгжсөн аймаг болоход иргэдийн ухамсар мэдлэгийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшил суулгахад оршино.

**Хугацаа:** 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 25

**Зохион байгуулагч:** Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сумдын Засаг даргын Тамгын газар

**Хамрах хүрээ:** Аймгийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, албан байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газар, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага оролцоно.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Хаврын улирал эхэлсэнтэй холбогдуулан шар усны үерээс хамгаалах, хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдал, усан сан бүхий газрын эрүүл хамгаалалтын бүсэд болон авто замын дагуух хуримтлагдсан малын сэг зэмийг халдваргүйжүүлэн устгах, хог хаягдлыг цэвэрлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулж, бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах,
2. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж бүхий талбай, сад, цэцэрлэгт хүрээлэнгийн хогийг цэвэрлэх, хашаа, хайсны өнгө үзэмжийг сайжруулах, засах, угааж цэвэрлэх;
3. Хог хаягдлын тухай хууль, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах нөлөөллийн ажлыг олон нийтийн сүлжээгээр сурталчлан үр дүнтэй, шинэлэг байдлаар зохион байгуулах;
4. Бүх нийтийн их цэвэрлэгээнээс гарсан дахивар хог хаягдлыг хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах ажлыг зохион байгуулах;

**Тайлан мэдээ ирүүлэх:** Сумын хэмжээнд хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хавсралт 2-ын дагуу файлаар болон албан бичгээр ирүүлнэ. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүн, сумдын оролцоо, тайлан мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



Улсын 2023 оны 05 дугаар сарын  
дугаар захирамжийн хоёрдугаа  
авсралт

БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ЗАГВАР ХҮСНЭГТ

[illegible]